

МОНГОЛБАНКНЫ САРЫН СТАТИСТИКИЙН БЮЛЛЕТЕНЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТАЛААР

Монголбанк Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй хадгаламжийн байгууллагуудын үзүүлэлтүүдийг үндэслэн Хадгаламжийн байгууллагуудын тоймыг сараар, бусад санхүүгийн байгууллагын үзүүлэлтийг нэгтгэсэн Санхүүгийн байгууллагуудын тоймыг улирлаар нийтэлж ирсэн.

Бусад санхүүгийн байгууллагын тоймд банк бус санхүүгийн байгууллагууд, Хөгжлийн банк, МИК ОССК-ий үзүүлэлтүүд тусгагдаж байна. Хөгжлийн банк, МИК ОССК-ийн үзүүлэлтүүд хурдтай нэмэгдэж байгаа тул сараар харуулах шаардлага зүй ёсоор гарч ирлээ. Иймээс бусад санхүүгийн байгууллагын тойм, санхүүгийн байгууллагын тойм улирлаар гардаг байсныг 2015 оны 5 дугаар сараас эхлэн сар бүр гаргах боллоо. ББСБ-уудын үзүүлэлт улирлын давтамжтай 2 сарын хоцрогдолтой шинэчлэгдэж байгаа бөгөөд шинэчлэгдэх хүртэл өмнөх улирлын тоог өөрчлөхгүйгээр тусгаж байгаа болно.